**ОРХОН АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 06 өдөр | Дугаар А/27 | Баян-Өндөр сум

Тусгай зөвшөөрөл шинээр олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хаягийн шилжилт хийх, нэр солих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.3.1, 19.12.3, 19.12.4, 19.18, Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2.1.1, 6.2.1.2 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай зөвшөөрлийн 2026 оны 04 дугаар сарын 06-ны өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрлийг шинээр олгох байгууллагыг нэгдүгээр, түдгэлзүүлэх байгууллагыг хоёрдугаар, тусгай зөвшөөрөл хүчингүй болгох байгууллагыг гуравдугаар, хаягийн шилжилт хийх байгууллагыг дөрөвдүгээр, эмнэлгийн нэр солих байгууллагыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн газарт сар бүрийн мэдээ тайланг хугацаанд нь ирүүлж, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, стандартуудыг хэрэгжүүлэн ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөтийн хэлтсийн Бодлого төлөвлөлт хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Уртнасан)-д даалгасугай.

ДАРГА Ц.МӨНХЦЭЦЭГ

9043446 2020030036

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
04.. дүгээр сарын 06-ны өдрийн
А/27. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

9043446 2020030036

ҮЙЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН НЭР,
ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

| № | Байгууллагын нэр | Үйл ажиллагааны чиглэл | Хаяг, байршил | Хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Дөлгөөн хурд цог ХХК-ийн “Дөлдент” клиник | Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (шүд) | Чандмань баг, 7 Эрээний гудамж 1 120/1 байр 102 тоот | 3 жил |
| 2 | Сэрүүн гялаад ХХК-ийн “Кристаллдент” | Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (шүд) | Оюут багийн Гранд гардены 10-5-р байрны 101 тоот | 3 жил |

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
04 дүгээр сарын 06-ны өдрийн
А/27 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

9043446 2020030036

## ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

| № | Байгууллагын нэр | Үйл ажиллагааны чиглэл | Хаяг, байршил | Түдгэлзүүлэх хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Мөнх-Алтаргана ХХК-ийн “Баялаг” 1-р зэрэглэлийн эмийн сан | Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах | Зэст баг, 1-р хорооллын 5-р байрны 14 тоот | 2026.04.06-05.06 хүртэл (1 сар) |

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
04 дүгээр сарын 06-ны өдрийн
А/27 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

9043446 2020030036

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

| № | Байгууллагын нэр | Үйл ажиллагааны чиглэл |
|---|---|---|
| 1 | ЗБЗ амьдрал бэлэглэгч ХХК-ийн “Мөнхийн үйлс” ор бүхий клиник | Уламжлалтын тусламж үйлчилгээ(амбулатори,хэвтэн, өдрийн эмчилгээ) |
| 2 | Чингүүн хишиг ХХК-ийн “Эрдэнэт Хоспис” клиник | Эмнэлгийн мэргэшсэн туссамж үйлчилгээ (хөнгөвчлөх тусламж) |
| 3 | Алое эсктра ХХК-ийн “Алое” 1-р вэрэглэлийн эмийн сан | Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах |

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
04 дүгээр сарын 16-ны өдрийн
А/27 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

9043446 2020030036

## ХАЯГИЙН ШИЛЖИЛТ ХИЙХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, БАЙРШИЛ

| № | Байгууллагын нэр | Үйл ажиллагааны чиглэл | Шилжиж орох байршил |
|---|---|---|---|
| 1 | Артакод ХХК-ийн “Катарсис” сэтгэц наркологийн клиник нь | Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ(сэтгэц, наркологи) | Цагаанчулуут багийн Дэлгэрэх 8-р гудамжны 804 тоотод байрлах Өгөөж төвийн 2 давхарт |

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
04 дүгээр сарын 06.ны өдрийн
А/27 дугаар тушаалын тавдугаар хавсралт

9043446 2020030036

ЭМНЭЛГИЙН НЭР СОЛИХ БАЙГУУЛЛАГА

| № | Байгууллагын нэр | Үйл ажиллагааны чиглэл | Эмнэлгийн байршил | Солих эмнэлгийн нэр |
|---|---|---|---|---|
| 1 | Цэлмэг эрдэнэ ХХК-ийн “Цэлмэг нар” клиник | Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ(чих хамар, хоолой) | Бүрэнбүст баг, 5-р хороололын 42 дугаар байрны нэг давхарт | Цэлмэг эрдэнэ ХХК-ийн “Приме” клиник болгох |